

БАТЛАВ:

БОЛОВСРОЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ДАРГА



...../ Т.НЯМ-ОЧИР /

АЙМАГ, СУМДЫН ТӨРИЙН ӨМЧИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ,  
ЦЭЦЭРЛЭГ, ДОТУУР БАЙРНЫ НҮХЭН ЖОРЛОНГ ОРЧИН ҮЕИЙН СТАНДАРТ  
ШААРДЛАГАД НИЙЦСЭН АРИУН ЦЭВРИЙН БАЙГУУЛАМЖ БОЛГОХ ТӨСӨЛ АРГА  
ХЭМЖЭЭНИЙ АЖЛЫН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ДААЛГАВАР

2022 оны 05-р сарын 05-ны өдөр

Дугаар №ЗД-05/2022

Улаанбаатар хот

1.	Зураг төсөл зохиох үндэслэл:	<ul style="list-style-type: none"><li>- Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр;</li><li>- Монгол Улсын Их Хурлын 2020 оны 39 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай;</li><li>- Монгол Улсын Засгийн Газрын 2021 оны 127 дугаар тогтоолоор батлагдсан Боловсролын салбарт хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын зарим арга хэмжээний тухай;</li></ul>
2.	Барилга байгууламжийн байршил:	<ul style="list-style-type: none"><li>- Монгол Улс. Завхан аймгийн сумдад одоо байгаа сургууль, цэцэрлэг, дотуур байрны орчмын талбай.</li></ul>
3.	Зураг төсөл боловсруулах үндэслэл:	<ul style="list-style-type: none"><li>- Монгол Улсын Боловсрол, шинжлэх ухааны Сайд, Барилга, хот байгуулалтын Сайд, Байгаль орчин, Аялал жуулчлалын Сайдын 2021 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн Ажлын хэсэг шинэчлэн батлах тухай А/401, 247, 371-р хамтарсан тушаал;</li><li>- Монгол Улсын Боловсрол, шинжлэх ухааны Сайдын 2022 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн Төсөл арга хэмжээний жагсаалт батлах тухай; А/99 дугаартай тушаал;</li></ul>
4.	Зориулалт, хүчин чадал, талбай:	<ul style="list-style-type: none"><li>- Тухайн аймаг сумдад одоо байгаа Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн суудлын тоогоор, цэцэрлэг, дотуур байрны орны тоогоор хүчин хүчин чадлыг тооцож орчин үеийн стандарт шаардлагад нийцсэн ариун цэврийн иж бүрэн барилга, байгууламжийг төлөвлөх.</li><li>- Тухайн байршилд байгаа сургууль, цэцэрлэг, дотуур байрны орчмын зөвшөөрөгдсөн нийт талбайн эдэлбэр газарт.</li></ul>
5.	Бэлтгэл ажил,	- Инженер геологийн судалгаа. дүгнэлт хийх

	судалгаа:	<ul style="list-style-type: none"> <li>- Дэвсгэр зургийн тодруулга хийх</li> <li>- Сургууль, цэцэрлэг, дотуур байрны хүчин чадлын судалгаа хийх</li> </ul>
6.	Зураг төслийн бүрэлдэхүүн:	<p>1.Цэвэрлэх байгууламж, тоног төхөөрөмж, автоматикийн ажлын зураг, төсөл;</p> <p>2.Цэвэрлэх байгууламжийн бохир усны цэвэрлэгээний технологийн схем, ажиллагааны зарчмын ажлын зураг төсөл;</p> <p>3.Ариун цэврийн өрөө, барилга байгууламж, тоног төхөөрөмжийн ажлын зураг, төсөл;</p> <p>3.Дээрх барилга байгууламжуудын халаалт, агаар сэлгэлт, цахилгаан, цэвэр бохир усны дотор шугам сүлжээ, эдгээрийг хангах эх үүсвэр, гадна шугам сүлжээний ажлын зураг, төсөл</p> <p>Эдгээр ажлын зураг төслийн бүрдэлд:</p> <ul style="list-style-type: none"> <li>➤ Нүүр хуудас /батлагдсан/</li> <li>➤ Байршлын схем, батлагдсан ХЕТ</li> <li>➤ Зургийн жагсаалт</li> <li>➤ Зураг төсөл боловсруулахад холбогдолтой баримт бичгүүд, хийсэн судалгаа, одоогийн байдлын зураг</li> <li>➤ Тайлбар бичиг, инженерийн тооцоо</li> <li>➤ Тодруулга хийсэн дэвсгэр зураг М1:500-:1000</li> <li>➤ Зай хэмжээ М1:500</li> <li>➤ Өндөржилт М1:500</li> <li>➤ Техник хэсэгт - ажлын зураг (дотор, гадна инженерийн шугам сүлжээ тус бүрийн байгуулалт, эдгээрийг нэгтгэсэн байгуулалт, материалын түүвэр, хэсэглэл, дагуугийн зүсэлт, угсралтын схем, цэвэрлэх байгууламжийн технологи, тоноглол, тэдгээрийн байгуулалт, тойм, инженерийн тооцоо)</li> <li>➤ Төсөв</li> <li>➤ Ажлын зураг төсвийг магадлалаар баталгаажуулсан байна.</li> </ul>
7.	Инженерийн хангамж шугам сүлжээ, түүнийг хангах эх үүсвэр:	<p><i>Цэвэрлэх байгууламж:</i> Тухайн сум бохир усны төвийн шугамгүй тохиолдолд хөрсний геологийн дүгнэлт, байгаль орчны үнэлгээ, бусад судалгаанд үндэслэн бага оврын цэвэрлэх байгууламж эсвэл Септик технологийн аль тохиромжтойг сонгох, Бага оврын цэвэрлэх байгууламж сонгосон тохиолдолд бүрэн автоматчилагдсан нэгдсэн удирдлагын системтэй байх.</p> <p><i>Бохир ус:</i> -Бохир усны төвлөрсөн шугам сүлжээтэй тохиолдолд олгогдсон техникийн нөхцлийн дагуу барилгуудыг төвлөрсөн шугамд холбох,</p> <p><i>Ус хангамж:</i> - Цэвэр усны төвлөрсөн шугам сүлжээтэй тохиолдолд олгогдсон техникийн нөхцөлийн дагуу барилгуудыг төвлөрсөн шугамд холбох, - Зөөврийн цэвэр усаар хангагдах тохиолдолд эрүүл ахуйн нөхцөл хангасан зориулалтын цэвэр усны нөөцийн савыг төлөвлөх, хянах мэдрэгчтэй байх,</p>

		<p>- Шаардлагатай байршилд гүний худаг төлөвлөж болно.</p> <p><i>Халаалт, агаар сэлгэлт:</i> Олгогдсон техникийн нөхцөлийн дагуу төвийн дулааны шугамд холбох, Төвийн шугамд холбох боломжгүй тохиолдолд дулааны өөрийн эх үүсвэрээр шийдэх, <i>Цахилгаан хангамж:</i> Олгогдсон техникийн нөхцлийн дагуу цахилгаанаар хангах ба эрчим хүчний тасалдал урт богино хугацаагаар үүсэхэд биологийн цэвэрлэгээг тасалдуулахгүйн тулд хүчин чадалд нь тохирсон нөөц эх үүсгэвэртэй ба тог үүсгэгч шийдэх, <i>Ариун цэврийн өрөөний дотор шугам сүлжээ:</i> Цахилгаан, гэрэлтүүлэг, халаалт агаар сэлгэлт, цэвэр бохир усыг бүрэн шийдсэн байх. Гадна инженерийн шугам сүлжээ, сувагчлал, тоноглол: Дулааны шугам, сувгийн хийцлэлд орчин үеийн техник, технологийн шийдлийг тусгасан байх Дулааны худаг, хоолойн сувагчлал, бохирын худаг нь төмөр бетон хийцтэй байх. Хоолойн материал – ган Ст20 Арматур- Ган бөмбөлгөн хаалт Компенсатор- П хэлбэрийн болон <i>сильфон</i> Дулаалгын гадуурх хамгаалалтын материалыг ус үл нэвтрэх материалаар сонгох Цэвэр, бохир усны гадна шугамд хөлдөлтөөс сэргийлсэн шийдэл гаргах.</p>
8.	Үйлдвэрлэл, үйлчилгээний зам, тээвэр:	<p>- Ногоон байгууламж: явган зам талбай, нийтийн эзэмшлийн талбайг МУ-ын Барилгын тухай хуулийн 12.1.4 дүгээр заалтыг мөрдөж төлөвлөнө.</p> <p>- Автозам: хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан авто замтай уялдуулах</p>
9.	Зургийн үе шат, хугацаа:	<p>- Нэг үе шаттай.</p> <p>- Гэрээнд заасан хугацаанд иж бүрэн зураг, төсвийг магадлалаар баталгаажуулж, захиалагчид хүлээлгэн өгнө.</p>
10.	Зураг, төслийн байгууллага:	<p>- Тендерт шалгарсан Зөвлөх үйлчилгээний эрх бүхий хуулийн этгээд байна.</p>
11.	Захиалагч болон хөрөнгө оруулагч байгууллага:	<p>- БШУЯ, - БХБЯ, - “Эрдэнэт” ТӨҮГ</p>
12.	Галын аюулгүй байдлын нөхцөл:	<p>- Барилга, байгууламжийн галын аюулгүйн байдал БНБД 21.01.02 - Барилга байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүйн норм БНБД 21.02.02</p>
13.	Байгаль орчны үнэлгээ, нөхцөл:	<p>- Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийлгэх.</p>
14.	Ажлын зурагт ашиглах материал, тавигдах шаардлага:	<p>-Тухайн сумдын батлагдсан хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан цэвэрлэх байгууламж болон дэд бүтцийн трассыг сонгоно. -Ажлын зургийг гүйцэтгэхдээ тухайн зөвлөхийн ажилтай</p>

		<p>холбогдох, Монгол Улсад дагаж, мөрдөгдөж байгаа бүхий л хууль, дүрэм, журам, БНБД-ийг мөрдлөгө болгон ажиллах.</p>
15.	Онцгой нөхцөл:	<ul style="list-style-type: none"> <li>➤ Талбайн зохион байгуулалтыг зөв төлөвлөсөн байх</li> <li>➤ Ажлын зургийг тухайн хэсэгчилсэн талбайд төлөвлөгдсөн авто зам, инженерийн бэлтгэл арга хэмжээ болон бусад инженерийн шугам сүлжээний төлөвлөлтийн ажлын зураг төсөлтэй уялдуулан гүйцэтгэж, трассыг дэвсгэр дээр нэгтгэн оруулж, хоорондын зай хэмжээг огтлолын зургаар тодорхой үзүүлж, норм стандартын дагуу төлөвлөж, шугам сүлжээний ашиглалтын байгууллагуудтай зөвшилцсөн байх шаардлагатай.</li> <li>➤ Авто зам, бусад шугам сүлжээний хамгаалалтын зурвасыг баримтлан төлөвлөх.</li> <li>➤ Зураг төслийн баримт бичгийг 4 хувь хийж захиалагчид өгөх.</li> <li>➤ Дулааны шугам болон авто зам, инженерийн бэлтгэл арга хэмжээ, бусад инженерийн шугам сүлжээний төлөвлөлтийн трассыг нэгтгэсэн байгуулалтын ажлын зургийг UTM, WGS-84-48N солбицлын нэгдсэн системд хийж гүйцэтгэн батлагдсан ажлын зургийг CD-ээр, бусад зураг баримт бичгийг тоон хэлбэр(DWG болон PDF)-ээр аймаг орон нутгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газарт хүлээлгэн өгөх.</li> <li>➤ Шугам сүлжээ болон түүнтэй холбогдох барилга байгууламжийн угсралтын ажил гүйцэтгэхэд эдийн засгийн хувьд үр ашигтай орчин үеийн дэвшилтэт техник технологи нэвтрүүлэн ашиглахаар тусгаж өгөх.</li> <li>➤ Цэвэрлэх байгууламжийн технологи нь Монгол орны байгаль цаг уурын нөхцөлд тохирсон, эдийн засгийн хувьд хэмнэлттэй хувилбар байх</li> <li>➤ Ашиглалтын зардал багатай, техник эдийн засгийн хувьд үр ашигтай.</li> <li>➤ Хүний оролцоо багатай буюу автомат ажиллагаатай байх.</li> <li>➤ Цэвэрлэх байгууламжийг эрс тэс цаг агаарын нөхцөлд /-40 хэмд/ тасралтгүй жигд ажиллагааг ханган ажиллахаар тооцох</li> <li>➤ Бохир усны лаг тунадасыг боловсруулах сав төлөвлөх, лагийг хоёрдогч бохирдол үүсгэх хаяхгүй байх, бүтээгдэхүүн болгох ногоон шийдэлтэй байх</li> <li>➤ Аваарын үед бохир усыг байгальд нийлүүлэхгүй байх шийдэл</li> <li>➤ Септик системээр шийдсэн тохиолдолд бохир ус соруулах лаг ачих автомашин орж гарах гарцыг зураг төсөвт тусгах</li> <li>➤ Хуучин нүхэн жорлонг буулгах хөрсийг ариутгах зөөж зайлуулах зардалыг зураг төсөвт тусгах</li> <li>➤ Одоо байгаа сургууль, цэцэрлэг, дотуур байран</li> </ul>

		<p>дотор байрлал сонгож ариун цэврийн өрөөг төлөвлөх.</p> <ul style="list-style-type: none"> <li>➤ Сонгосон ариун цэврийн өрөөнд сургууль, цэцэрлэг, дотуур байрны хүчин чадлаар эрэгтэй, эмэгтэй хүүхдийн ариун цэврийн өрөө, багш ажилчдын ариун цэврийн өрөө, тусгай хэрэгцээт хүүхдийн ариун цэврийн өрөөнүүдийг норм, стандартын дагуу төлөвлөх.</li> <li>➤ Шаардлагатай тохиолдолд дулааны шугам сүлжээг тухайн цэгүүдэд (зам, үерийн далан суваг болон бусад шугам сүлжээтэй огтлолцсон хэсгүүдэд) нэмэлт арга хэмжээг авч хүчитгэсэн нэвтрэх суваг төлөвлөх</li> <li>➤ Сургууль, цэцэрлэг, дотуур байрны барилгуудын хоорондын зай хэмжээнээс шалтгаалж цэвэрлэх байгууламжийг аль болох дунд нь нэг болгож техникийн болон эдийн засгийн ашигтай хувилбараар төлөвлөх.</li> <li>➤ Мөнх цэвдэг, ус шингэдэггүй хөрсөнд халдваргүйжүүлэлт шүүх талбай төлөвлөх</li> <li>➤ Усны эх үүсвэр хангалттай эсэхийг судлах</li> <li>➤ Сумдын ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулах</li> <li>➤ Байгаа барилгын хийц, ашиглалтын өнөөгийн байдлыг судалж дотор заслыг хийх.</li> </ul>
16.	Эдийн засгийн тооцоо, төсөв	<ol style="list-style-type: none"> <li>1. Төсөвт ашиглалт хариуцах ажилтнуудад сургалт зохион байгуулах зардлыг тооцно.</li> <li>2. Мөн цэвэрлэх байгууламж болон орчин үеийн ариун цэврийн байгууламжийн ашиглалтыг хариуцах ажиллах хүчний болон ашиглалтын үед гарах бүхий л зардлуудыг тооцсон байна.</li> <li>3. Буулгалтын болон угсралтын ажлын төсвийг боловсруулахдаа "Төсөв зохиох дүрэм" БНБД 81-95-12 нормыг ашиглана.</li> <li>5. Төсвийг ESTIMATOR-PRO программ болон эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн бусад програмаар тооцно.</li> </ol>

ХЯНАСАН:

БОЛОВСРОЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭРЭГЖИЛТ,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА



Ш.АЛТАНГЭРЭЛ

БОЛОВСРУУЛСАН:

БОЛОВСРОЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭРЭГЖИЛТ,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН



Б.АМАРЗАЯА